



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/03

Мөрөн сум


Тендерийн баримт бичгийн өгөгдлийн
хүснэгт, гэрээний маягт, нөхцлийг бэлтэх
загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгүүд, аймгийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны А/68 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар ажил нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох Тендерийн баримт бичиг бэлтгэх загвар, аргачлалыг нэгдүгээр, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бараа нийлүүлэгчийг сонгох тендерийн баримт бичиг бэлтгэх загвар, аргачлалыг хоёрдугаар, харьцуулалтын аргаар ажил нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичиг бэлтгэх загвар, аргачлалыг гуравдугаар, харьцуулалтын аргаар бараа нийлүүлэгчийг сонгох тендерийн баримт бичиг бэлтгэх загвар, аргачлалыг дөрөвдүгээр, зөвлөх үйлчилгээ худалдан авах тендерийн баримт бичиг бэлтгэх загвар, аргачлалыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай .

2. Захиалагчийн тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний маягт, гэрээний тусгай нөхцөлийг Сангийн сайдын баталсан жишиг тендерийн баримт бичигт үндэслэн бэлтгэх загвар, аргачлалыг мөрдөн ажиллахыг үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (Б.Болд)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ДОЛЖИНСОРОГДОГ



Орон нутгийн өмчийн газрын даргын
2022 оны 1 дүгээр сарын 24-ний
өдрийн дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

2022 оны дүгээр сарын-ны өдөр

ЛӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР/ АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ
БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:

/Төсөл арга хэмжээний нэрийг
батлагдсан жагсаалтын дугаарын
хамт бичих/

Тендер шалгаруулалтын дугаар:

.....

Цахим хаяг: khuvsgul.tender.gov.mn

БАТЛАВ:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДОЛЖИНСОРОГДОГ

ХЯНАСАН:
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
АЛБАНЫ ДАРГА

Б.БОЛД

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ
ДАРГА

.....

БОЛОВСРУУЛСАН:
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

.....

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТААР АЖИЛ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо¹ : *[тендер зарласан он, сар,
өдрийг бичих]*

Тендер шалгаруулалтын нэр: *[төсөл, арга хэмжээний
батлагдсан нэрийг бичих]*

Тендер шалгаруулалтын дугаар: *[цахим системд заасан
тендер шалгаруулалтын
дугаарыг бичих]*

[Захиалагчийн нэрийг бүрэн, товчлохгүйгээр бичих] нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг *[тендер шалгаруулалтын нэр]*-ыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: *[Хэрвээ багцтай бол “Тийм”, багцгүй бол “Үгүй”]*

Багц 1: *[багцын нэр]*

Багц 2: *[багцын нэр]....*

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш [30] ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заах ба *[баталгааны үнийн дүнг бичих]*² төгрөгөөс багагүй үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.³

Тендерийг *[тендер хүлээн авах эцсийн огноо, цаг]*-аас өмнө тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг *[огноо]-ны өдрийн, [цаг]*⁴-т зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх:⁵ *[“Эрхтэй” эсхүл “Эрхгүй” гэдгийн аль нэгийг сонгоно уу]*

Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: *[“Тийм” эсхүл “Үгүй” гэдгийн аль нэгийг сонгоно уу]*

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

¹ Тендерийн урилгыг анх зарлан мэдээлсэн өдөр байна.

² Төсөвт өртгийн 1-2 хувьтай тэнцүү байна.

³ 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил, 70 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, зөвлөхөөс бусад үйлчилгээ худалдан авахад тендерийн баталгаа шаардана.

⁴ Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

⁵ Хуулийн 9.3-т зааснаас бусад тендер шалгаруулалтад гадаадын этгээдийг оролцуулж үл болно.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг,

Чүнгүүнжавын талбай, Хөвсгөл аймгийн удирдлагын ордон,

Утас: 70388849, 70383809, 70388821,

Цахим хаяг: khuvsgul.tender.gov.mn

БАТЛАВ:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ДОЛЖИНСОРОГДОГ

ХЯНАСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ

АЛБАНЫ ДАРГА

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

Б.БОЛД

БОЛОВСРУУЛСАН:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

.....

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОХ ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Аймгийн Засаг даргын Тамгын газар Аймгийн орон нутгийн өмчийн газар
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <i>[төсөл, арга хэмжээний батлагдсан нэр, дугаарыг бүтэн бичих]</i>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: <i>[цахим системд заасан тендер шалгаруулалтын урилгын дугаарыг бичих]</i>
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багц № 1: багцын нэр,</i> <i>Багц № 2: багцын нэр...гэх мэт.</i>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>[Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалт эсхүл Аймгийн 2022 оны төсвийн хөрөнгө оуулалт: Орон нутгийн хөгжлийн сан, авто замын сан, Орон нутгийн хөрөнгө оруулалт, Байгаль хамгаалах сан гэх мэтээс тохирохыг үлээнэ үү]</i>

ТШЗ 2.1	<p>Нийт төсөвт өртөг: [мөнгөн дүн бичих]</p> <p>[Хэрэв багцад хуваасан бол багц тус бүрийн төсөвт өртгийг бичих:</p> <p>Багц №...: _____</p> <p>Багц №...: _____]</p>
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА	
ТШЗ 8.2	<p>Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:</p> <p>Хүлээн авагчийн нэр: Хөвсгөл аймгийн Орон нутгийн орон нутгийн өмчийн газар</p> <p>Хаяг: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар баг, Чингүүнжавын талбай, аймгийн удирдлагын ордны байр, Орон нутгийн өмчийн газар</p> <p>Утасны дугаар: [70388849, 70388821, 70383809]</p> <p>Цахим шуудангийн хаяг: <i>khuvs gul.tender.gov.mn</i></p> <p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоног байна.</p> <p>Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна.Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна.</p>
ТШЗ 9.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	<p>Тендерт гадаадын этгээд оролцох:Эрхгүй</p> <p>Тендерийн хэл Монгол хэл байна. Гадаад хэл дээрх бүх материалыг орчуулгын хамт ирүүлнэ.</p>
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 16.1	<p>Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай.</p> <p>Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.</p>

	<p>/Тендерт оролцогчийн ирүүлсэн татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй./</p>
ТШЗ 16.1	<p>Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ирүүлэх: шаардлагагүй бөгөөд "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгана.</p>
ТШЗ 16.2.1	<p>Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна.</p> <p>Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.</p> <p>Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж архивын лавлагаа авах хүсэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт илгээх бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хянан үзэж цахим хэлбэрээр ирүүлдэг болохыг анхаарна уу!</p> <p>Жич: Дээрх 2 лавлагаа авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</p>
ТШЗ 17.2	<p>Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: "Шаардана"</p> <p>- Борлуулалтын орлогын хэмжээ: 2019, 2020, 2021 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.</p>
ТШЗ 17.2.5	<p>Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: "Шаардана"</p> <p>1. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 20 хувиас багагүй байх.</p> <p>Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ • Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээл олгох боломжтой тухай тодорхойлолт ирүүлнэ. • Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд; <p>Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр, төлбөргүй талаарх тодорхойлолтыг ирүүлнэ.</p>
ТШЗ 17.3	<p>Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа:</p> <p>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019, 2020, 2021 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй. Санхүүгийн тайланг цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс татаж тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас 2019, 2020, 2021</p>

	онуудын борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.												
ТШЗ 17.6	<p>Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p>Ижил төстэй ажлыг доод тал нь ядаж нэг удаа гүйцэтгэгдсэн байвал зохих жилийн тоо: Сүүлийн 5 жилийн аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй/захиалагчаас санал болгосон ажил түүнтэй дүүцхүйц ажлын нэрийг бичих/.....ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх. /Ажил гүйцэтгэсэн гэрээ, ажлыг ашиглалтад хүлээн авах комиссын акт (дүгнэлт)-ийн эхээс хийсэн хуулбар (Комиссын дүгнэлт нь Засгийн газрын 2021 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоолын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан баталгаажуулсан байна.)</p>												
ТШЗ 17.6.1	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: [<i>"Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих Хэрэв шаардах бол зөвшөөрөл олгодог байгууллага, тусгай зөвшөөрлийн нэрийг тодорхой бичих]</i></p> <p>Тендерт оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс шалгах тул тусгай зөвшөөрлийн хуулбарыг тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй.</p> <p><i>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дэх тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт эсэхийг тендерт оролцогч нь нягтлах үүрэгтэйг анхаарна уу.</i></p>												
ТШЗ 17.6.2	<p>Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: "Шаардана" Тендерт оролцогч нь дараах хүснэгтэд заасан албан тушаал, ур чадвар, туршлага, мэргэжил бүхий хүний нөөцийг санал болгох үүрэгтэй.</p> <table border="1" data-bbox="604 1733 1934 2006"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</th> <th>Мэргэжил</th> <th>Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table> <p>- Дээрх хүснэгтэд заасан инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг маягтын дагуу үнэн зөв гаргаж, ажилтнуудын ажлын туршлагын мэдээллийг хүн тус бүрээр баталгаажуулж ирүүлбэл зохино. Энэхүү төсөл, арга хэмжээнд ажиллуулах ажилтнуудыг томилсон захирлын тушаалын эх хувиас татсан хуулбар болон инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ. Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу. Хэрэв гадаад улсын их,</p>	№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх						
№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх								

	<p>дээд сургууль, коллежид боловсрол эзэмшсэн этгээдийг төсөл арга хэмжээнд ажиллуулах тохиолдолд дипломын хуулбарыг тендерт ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. https://bit.ly/3J1QmHZ - Хэрэв инженер, техникийн ажилтнууд нь гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ. - Хөлсөөр ажиллуулах гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна. - Мэргэжилтэй ажилчдын жагсаалтыг ирүүлнэ. <p>Дээрх инженер, техникийн ажилтнуудын 50 ба түүнээс доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг 2021 оны 10, 11, 12 дугаар саруудад тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгах тул НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй.</p>												
<p>ТШЗ 17.6.3</p>	<p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: [<i>“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих</i>]</p> <p>Заиалагч “Шаардана” гэж сонгосон тохиолдолд тендерт оролцогч нь доорх хүснэгтэнд дурьдсан зориулалт, шаардлагыг хангасан машин механизм, техник хэрэгслийг санал болгоно.</p> <table border="1" data-bbox="583 1439 1921 1676"> <thead> <tr> <th>№</th> <th>Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт</th> <th>Хүчин чадал</th> <th>Тоо ширхэг</th> <th>Улсын дугаар</th> <th>Эзэмшигчийн мэдээлэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> </tbody> </table> <p>1. Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн машин механизмуудыг дээрх жагсаалтын дагуу санал болгоно.</p> <p>2. Түрээсээр ашиглах бол түрээсийн гэрээг улсын дугаарыг харуулсан фото зургийн хамт ирүүлнэ. Түрээсийн гэрээг тендер зарласан өдрөөс хойш зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад асуудлыг тодорхой тусгасан байх.</p> <p>3. Дээрх хүснэгтэд заасан, гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн машин механизмуудын 50 ба түүнээс доошгүй хувь нь тендерт оролцогчийн өөрийн эзэмшлийнх байх шаардлагатай.</p> <p>Тухайн ажилд санал болгож буй тээврийн хэрэгсэл, машин механизмын гэрчилгээ, лавлагааг ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан шаардлагатай мэдээллийг шалгана.</p>	№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	Улсын дугаар	Эзэмшигчийн мэдээлэл						
№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	Улсын дугаар	Эзэмшигчийн мэдээлэл								
<p>ТШЗ 17.6.4</p>	<p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: [<i>“Шаардлагатай” эсхүл “Шаардлагагүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих.</i>]</p> <p>Шаардлагатай гэх тохиолдолд доорх хүснэгтэд заасан мэдээллийн дагуу ижил төстэй ажлын жагсаалтыг ирүүлнэ.</p> <table border="1" data-bbox="598 2552 1879 2745"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээний нэр</th> <th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс</th> <th>Төсөвт өртөг</th> <th>Дууссан, эсхүл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөвт өртөг	Дууссан, эсхүл дуусах хугацаа							
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөвт өртөг	Дууссан, эсхүл дуусах хугацаа									

	<p>1.</p> <p>Одоо гүйцэтгэж байгаа 70 хувиас дээш хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй ажлыг туршлагад тооцуулах бол тайлбар болон ажлын гүйцэтгэлийн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.</p>
<p>ТШЗ 17.6.5</p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: ["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих. Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: "Шаардана" гэх тохиолдолд тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн тендерт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь оны дугаар сарын-ны өдөр байна. 2. Ажлын зураг, төсвийн дагуу тооцсон төсөв зохиож, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй хууль, тогтоомж, журам, зааврын дагуу төсөв зохиох программаар гүйцэтгэнэ/ 3. Хяналтын төсөвт тусгасан зураг төслийн үнэ/тоогоор/..... (...../үсгээр/.....) төгрөгийг өөрийн санал болгосон өртгийн төсөв/үнийн санал/-т багтаан тооцож ирүүлнэ. 4. Захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардлыг барилгын төсөв зохиох норм дүрмийн дагуу тооцон ирүүлнэ. 5. Тендерт оролцогч нь олон багц ажлын тендерт оролцох болон өөр ижил төстэй ажил гүйцэтгэж байгаа бол зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд ажиллуулах инженер техникийн ажилтан, машин механизмуудыг санал болгоно. Энэ тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, машин механизм нь 70 хувиас бага гүйцэтгэлтэй ажилд давхацсан тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. /Одоо гүйцэтгэж байгаа дуусаагүй ажилтай бол тайлбар болон ажлын гүйцэтгэлийн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ./ 6. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ, өөрийн ирүүлсэн төсвийн дүнтэй арифметик алдаанаас бусад тохиолдлоор зөрсөн, эсвэл үнийн хөнгөлөлт үзүүлж буй тохиолдолд үндэслэл шалтгааныг дурдсан мэдэгдлийг шаардлагатай нотлох баримтын хамт баталгаажуулан ирүүлнэ. Хэрэв бараа, материалаас үнийн хөнгөлөлт үзүүлж буй тохиолдолд бараа нь тендерт оролцогчийн санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн байна. Үндэслэлгүй тооцсон үнийн хөнгөлөлт бүхий тендерээс татгалзана. 7. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. 8. Тендерт оролцогч нь захиалагчийн тендерийн баримт бичгийн гэрээний маягт, гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа талаарх мэдэгдлийг албан бичиг хэлбэрээр ирүүлнэ. <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.</p> <p>Тендерт оролцогч нь Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 255 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-тай танилцахыг зөвлөж байна.</p>

ТШЗ 17.7.	<p>Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: ["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэж бичих] "Шаардана" гэж сонгосон тохиолдолд захиалагчийн тендерийн баримт бичгийн ТШЗ 17.6-д заасан хугацаанд хэрэгжүүлсэн гэрээний мэдээллийг захиалагчийн тендерийн баримт бичгийн ТШЗ 17.6.4-д заасан маягтаар тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүд баталгаажуулж өөрийн тендерт ирүүлнэ. Одоо гүйцэтгэж байгаа дуусаагүй 70-аас дээш хувийн гүйцэтгэлтэй ажлын гүйцэтгэлийн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.</p>
ТШЗ 17.8	<p>Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчтэй оролцох бол гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хүртэл хувь байна. Дараах материалыг ирүүлэх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчтэй цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байна. Гэрээнд туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажил үүрэг, гэрээний үнийн дүн, хугацааг тодорхой тусгасан байна. 2. Туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна. <p>Туслан гүйцэтгэгч нь Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд уг мэдээллийг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгана.</p>
ТШЗ 17.9	<p>Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.(а) түншлэлийн гэрээ нь Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан байна. (б) Түншлэлийн гэрээнд түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн болон түншлэлийн гишүүдийг тодорхойлж, түншлэлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх ажил, үнийн дүн, хувийг тодорхой тусгасан байна. (в) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох; (г) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцохыг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх; (д) түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх. (е) түншлэлийн гишүүн бүр энэхүү ТӨХ-д заасан бүх мэдээллийг тус бүрдээ гаргаж, тендерийн хамт ирүүлнэ. <p>Хамгийн доод шалгуур:</p> <p>Түншлэл нь ТШЗ-ны 17.2, 17.6-д заасан доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. ТШЗ-ны 17.2-т борлуулалтын орлого, гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ, ТШЗ-ны 17.6-д ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг тус тус заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.</p> <p>Дээрх шаардлагыг түншлэлийн гэрээнд тусгаагүй тохиолдолд түншлэлийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.</p> <p>Анхааруулга: Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журмын 3.3.1-д "Тендерт оролцогч нь түншлэлээр оролцох бол талууд цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байх;" гэж заасны дагуу цахим системээр дамжуулан гэрээ байгуулаагүй тохиолдолд уг журмын 3.11-д "Тендерт оролцогч тендер илгээхдээ журмын 3.3.1-д зааснаар түншлэлийн бусад гишүүдтэй гэрээ байгуулаагүй бол хуулийн 5.1.6.б-д</p>

	заасан тендерт оролцогч гэж үзэхгүй” гэж заасны дагуу түншлэлээр тендерт оролцсон гэж үзэхгүй болохыг анхаарна уу.
ТШЗ 19.5.	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: [<i>“Тохирүүлж болно” эсхүл “Тохируулахгүй тогтмол байна” гэж бичих. Хэрэв гэрээний үнийг тохируулах бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг захиалагч тендер зарлахаас өмнө урьдчилан тогтоож, аргачлалыг гэрээнд тусгана.</i>]
ТШЗ 22.1	Тендерийн баталгаа: [<i>“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэж бичих. Хэрэв тендерийн баталгаа шаардах бол тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 1-2 хувиар тооцож мөнгөн дүнгээр багц тус бүрээр доорх байдлаар заана:</i> <i>Багц №1: [●] төгрөг;</i> <i>Багц №2: [●] төгрөг.</i>]
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 23.1	Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг баталгаажуулан тендер шалгаруулалтад илгээнэ. Үүсгэн байгуулагдсан улсын хууль тогтоомжоор шаардаагүй бол тамга, тэмдэг дарахгүй байж болно
ТШЗ 23.3	Хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээс итгэмжлэлээр эрх олгогдсон этгээд нь өөрийн гарын үсэг, эсхүл тоон гарын үсгээр тендерийг баталгаажуулж тендер шалгаруулалтад илгээсэн байна.
ТШЗ 23.5.3	ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: (Үнэлгээний хороо нь доорх баримт бичгийн жагсаалтаас тухайн тендер шалгаруулалтад хамаарахгүй баримт бичгийг хасна. Энэ заалтыг тендерийн баримт бичгээс устгана) 1.Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлтэй болохыг нотлох баримт бичиг 2.Тендерийн баримт бичгийн ТШЗ 17.2-т заасан жилүүдийн борлуулалтын орлогыг нотлох баримт бичиг 3. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг нотолж, байгууллагын дансны үлдэгдлийг нотлох баримт бичгээс бусад баримт бичиг (тендерийн баримт бичиг ТШЗ 17.2-т заасан) 4. Ижил төстэй ажил гүйцэтгэж байсныг нотлох тендерийн баримт бичгийн ТШЗ 17.6-д заасан баримт бичиг 5. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл, 6. Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн машин механизм, техник хэрэгсэлтэй болохыг нотлох тендерийн баримт бичгийн ТШЗ 17.6.3-т заасан баримт бичиг, 7. Тендерийн баримт бичгийн ТШЗ17.6.4-т заасан ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл, 8. Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох ТШЗ 17.6.5-т заасан бусад баримт, 9. Түншлэлийн гишүүдийг тодорхойлох ТШЗ 17.9-т заасан баримт бичиг, 10. Тендерийн баталгаа, Тендерт оролцогч нь Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг

	бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ.
ТШЗ 24.1.	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <i>[он, сар, өдрийг бичих]</i></p> <p>Цаг: <i>[цаг, минутыг тодорхой бичих]</i></p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</p>
ТШЗ 26.1.	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <i>[он, сар, өдрийг бич. Жишээ нь: 20.. оны .. дугаар сарын ..-ны өдөр]</i></p> <p>Цаг: <i>[цаг, минутыг тодорхой бич. Жишээ нь: .. цаг .. минут г.м]</i></p> <p>Тендер нээх газрын хаяг: Хөвсгөл аймгийн Мөрөн сум, 8 дугаар баг, Удирдлагын ордон, Орон нутгийн өмчийн газар</p>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 30.2	<p>Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: <i>["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих]</i></p> <p><i>Хэрэв "Ашиглах" бол IV бүлгийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтээс аль тохирохыг тусгана]</i></p>
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 39.1	<p>Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <i>["Тийм" эсхүл "Үгүй" гэж бичих]</i></p> <p><i>[Хэрэв "Тийм" гэж хариулсан бол доорх өгүүлбэрийг бичих:</i></p> <p><i>ТШЗ-ны 7.5-д заасан гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.]</i></p>
Ё. БУСАД	
ТШЗ 41.1	<p>Урьдчилгаа төлбөр олгох эсэх: "Тийм"</p> <p>Урьдчилгаа төлбөрийн баталгааны мөнгөн дүнтэй тэнцэхүйц хэмжээний урьдчилгаа төлбөр олгож болно.</p> <p>Гэрээнд заасан маягтын дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлнэ.</p>
ТШЗ 43.1	<p>Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: Үгүй</p> <p><i>[Хэрэв "Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам"-аар зохион байгуулах бол "Тийм" гэж бичих]</i></p>

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

Мөрөн сум

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь "Ажил" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендер;
Ажлын зураг төсөл, өртгийн хяналтын төсөв;
 - 3.3. Гэрээний 1 дүгээр хавсралт (Гэрээний ерөнхий нөхцөл)
 - 3.4. Гэрээний 2 дугаар хавсралт (Гэрээний тусгай нөхцөл)
 - 3.5. Гэрээний 3 дугаар хавсралт(Барилга байгууламжийн ажлын үе шатанд хийх ажлын хуваарь⁶):
 - 3.6. Гэрээний 4 дүгээр хавсралт (Ажил, материал, бүтээц хийцийн техникийн тодорхойлолт)
 - 3.7. Гэрээний 5 дугаар хавсралт (Санхүүжилтийн хуваарь);
 - 3.8. Гэрээний 6 дугаар хавсралт (..... банкнаас гаргасан дугаартай төгрөгийн дүнтэй гүйцэтгэлийн баталгаа);
 - 3.9. Гэрээний 7 дугаар хавсралт (..... банкнаас гаргасан дугаартай төгрөгийн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгаа);
 - 3.10. Гэрээний 8 дугаар хавсралт (Бусад шаардлагатай баримт бичиг⁷);

4. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

5. ЗАХИАЛАГЧ, ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Захиалагч, гүйцэтгэгч нь холбогдох хууль тогтоомж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, хариуцлагыг хүлээнэ.

5.2. Гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг ажил дууссан тухай мэдэгдэл (Улсын комиссын акт) гарснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байлгана.

⁶ Нэгж үнийн гэрээнд "үе шатны ажлын хуваарь" гэснийг "ажлын тоо хэмжээ" гэж солино.

⁷ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээт ажил дуусаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөхийг хориглох бөгөөд баталгаа чөлөөлсөн нөхцөлд захиалагчийн шийдвэрээр гэрээг цуцлана.

5.3. Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сүүлийн санхүүжилтээс суутган тооцож 1 жилийн хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулна.

5.4. Ажлыг Улсын комисс болон захиалагчийн ажлын хэсэгт хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацааны 1 жил болон Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэгт заасан 3 жилийн хугацаанд чанаргүй болон дутуу гүйцэтгэлийн улмаас барилга байгууламж, тоног төхөөрөмж, материал бүтээцэд гарсан зөрчил, гологдлыг засварлах шаардлага гарсан тохиолдолд захиалагч нь гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ.

5.5. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг бүрэн, чанартай гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

5.6. Гүйцэтгэгч нь гэрээний 5.4 дахь хэсэгт заасан мэдэгдэл авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гүйцэтгээгүй тохиолдолд захиалагч энэхүү гэрээний 5.3 дахь хэсэгт заасан барьцаа хөрөнгөөс гарган засварын ажлыг бусад этгээдээр гүйцэтгүүлэх буюу үүргээ гүйцэтгээгүй гүйцэтгэгчийг "Тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл"-д бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хандана.

5.7 Барилгын ажлын гэрээний төлбөрийг санхүүжилтийн хуваарийн дагуу гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжүүлэх бөгөөд гэрээний төлбөрийн үлдэгдэл 20-аас доошгүй хувийн санхүүжилтийг барилгын ажлыг дуусган улсын комисст хүлээлгэн өгч, гэрээ дүгнүүлсний дараа олгоно.

5.8. Ажил нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөхгүй.

5.9. Зайлшгүй шаардлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож гэрээний үнэ, ажлын тоо хэмжээнээс бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж болох бөгөөд тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болсонд тооцно.

5.10 Гүйцэтгэгчид олгох гэрээний төлбөрөөс дараах зардлуудыг захиалагчийн холбогдох дансанд суутгана. Үүнд:

- Зураг төсөв, инженер геологи, эксперт үнэ: /...../ төгрөг
 - Захиалагчийн хяналтын зардал: /...../ төгрөг
 - Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал: /...../ төгрөг
 - Магадлашгүй ажил: /...../ төгрөг
- Зураг төсөвт тусгагдаагүй зайлшгүй хийгдэх болзошгүй ажлын зардлыг магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлж болно.

5.11. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөр төлөх болон чанарын баталгааны барьцаа хөрөнгийг гүйцэтгэгчид чөлөөлөн олгох үүрэг хүлээнэ.

5.12. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

5.13 Талуудын санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг дүгнэж хохиролыг тооцож хохирол тооцсон мэдэгдлийг хариуцагч талд хүргүүлж, гэм буруутай тал хохиролыг барагдуулна.

5.14. Барилгын талбайд байгаа материал, бүтээцийн лабораторийн шинжилгээ, сертификат, тохиролын гэрчилгээг барилгын талбайд байлгах, угсралт, суурилуулалтад оруулахаас өмнө захиалагчаар хянуулж, холбогдох зөвшөөрлийг авсан байна.

6. ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6.1. Гүйцэтгэгч нь ажлын тендерт өөрийн ирүүлсэн баримт бичиг, ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн зураг, төсөв, баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.

6.2. Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

6.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.

6.4. Гүйцэтгэгч нь захиалагчаас хүлээн авсан ажлын талбай болон барилга байгууламж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.

6.5. Гэрээнд хамаарах хууль тогтоомжийн холбогдох заалт болон энэ гэрээний ерөнхий нөхцөл, захиалагч, гүйцэтгэгчийн эрх, үүрэг, тусгай нөхцөл, бусад нөхцөлийг зөрчсөн тал "Захиргааны ерөнхий хууль"-ийн 56 дугаар зүйлийн 56.1, "Барилгын тухай хууль"-ийн 50 дугаар зүйл, "Иргэний хууль"-ийн 222 дугаар зүйлийн 222.4, 223 дугаар зүйлийн 223.1, 223.2, 225 дугаар зүйлийн 225.5, 227 дугаар зүйлийн 227.1, 227.3, 227.5, 229 дүгээр зүйлийн 229.1, 230 дугаар зүйлийн 230.1, 230.2, 231 дүгээр зүйлийн 231.1.1, 231.1.3, 232 дугаар зүйлийн 232.6, 234 дүгээр зүйлийн 234.4, 249 дүгээр зүйлийн 249.1, 349 дүгээр зүйлийн 349.1, 355 дугаар зүйлийн 355.6, 457 дугаар зүйлийн 457.10 дахь хэсгүүдэд заасан хариуцлагыг хүлээнэ.

6.6. Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

7. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ.

Гэрээг дор дурьдсан үндэслэлээр цуцална. Үүнд:

7.1 "Захиргааны ерөнхий хууль"-ийн 56 дугаар зүйлийн 56.2, 56.3, "Иргэний хууль"-ийн 221 дүгээр зүйлийн 221.3, 225 дугаар зүйлийн 225.3, 225.7, 240 дүгээр зүйлийн 240.1.2, 249 дүгээр зүйлийн 249.1, 356 дугаар зүйлийн 356.1, 356.2, 356.3 дахь хэсгүүд энэ гэрээний ерөнхий нөхцөлийн 56.2 дахь хэсэг, гэрээний тусгай нөхцөл, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан гэрээнээс татгалазах, гэрээг цуцлах нөхцөл байдал тус тус бий болсон

7.2 Захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээг сунгах бололцоогүй болсон эсхүл ажлын үе шатны хуваарьт заасан ажил хийгдээгүй, чанаргүй гүйцэтгэл гарсан, барилгын ажилын гүйцэтгэлийг хийхдээ мэргэжлийн алдаа гаргасан захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтыг хангахааргүй материалыг ашигласан зэрэг нь эрх бүхий албан тушаалтны дүгнэлтээр тогтоогдсон

7.3 Гүйцэтгэгч гэрээний үүрэг, захиалагчийн болон эрх бүхий хяналт шалгалтын байгууллагын дүгнэлт албан шаардлагыг биелүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн, эсхүл захиалагчаас хүлээн авсан ажлын талбай, барилга байгууламжийг учирч болох эрсдлээс хамгаалах, зүй зохистой ашиглах арга хэмжээ аваагүй, гэрээний үүргээсээ өөрөө татгалзсан зэрэг тохиолдолдлууд,

7.4 Гэрээг цуцалж байгаа тохиолдолд гэрээ цуцалж байгаа тал нь нөгөө талдаа энэ тухай хуанлийн 14 хоногийн өмнө мэдэгдэнэ.

8. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

8.1. Гэрээг 5 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2 хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдөр гэрээ хүчин төгөлдөр болно.

8.2 Сангийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 30-ний өдрийн 145 дугаар тушаалын хавсралтаар баталсан “ажил худалдан авах ажиллагаа”-ны тендерийн жишиг баримт бичгийн гэрээний ерөнхий нөхцөл, гүйцэтгэлийн баталгаа болон энэ гэрээний 3 дахь хэсэгт заасан баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

8.3 Энэхүү гэрээний нөхцөлд заасан ажлын тоо хэмжээ, үнэ өөрчлөхөөс бусад асуудлаар нэмэлт гэрээ байгуулж болох бөгөөд уг нэмэлт гэрээ нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

8.4 Энэхүү гэрээ нь гэрээг цуцалснаас бусад тохиолдолд “Барилгын тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэгт заасан хугацаа дуусах өдөр хүртэл хүчинтэй байна.

9. ГЭРЭЭ ДҮГНЭХ

9.1 Захиалагч болон гүйцэтгэгч байгууллага хамтран ажил гүйцэтгэх гэрээг дүгнэнэ.

9.2 Барилга угсралтын ажлын үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг тухайн үе шатанд хийгдсэн ажлын гүйцэтгэл, гэрээний бусад нөхцлийг үндэслэн дүгнэнэ.

9.3 Барилгын ажлын гүйцэтгэл бүрэн дууссан тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч, ашиглагч, зохиогч хамтран уг барилга багууламжид үзлэг шалгалт хийсэн тухай техник хяналтын нэгдсэн дүгнэлт болон Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан баримт бичгийг захиалагчаас аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлнэ.

9.4 Байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах асуудлыг аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар зохион байгуулна.

10. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

10.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

10.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх/-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

.....

.....
Б.ДОЛЖИНСОРОГДОГ

**НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОХ ТЕНДЕРИЙН ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

ГЕН 4.1.	Ажил эхлэх хугацаа: 2022 оны сарын.... -ны өдөр
ГЕН 4.2.	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: 2022 оны сарын.... -ны өдөр
ГЕН 4.9.	Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 5.2.	<p>Үнийн тохируулга: ["Хийнэ", "Хийхгүй" аль нэгийг сонгох] Хэрвээ тохируулга хийх бол: [Зөвхөн үндсэн материал, түүхий эд, ажиллах хүчний зардлын хэлбэлзлийг тусгах зорилгоор үнийн тохируулга хийнэ. Ингэхдээ төлбөрийн мэдэгдлийн нийт дүнгээс урьдчилгаа төлбөрийг хассан дүнгийн төлбөр хийх валют тус бүрийн үнийн дүнг холбогдох үнийн тохируулгын үзүүлэлт (P_c)-ийг ашиглан тохируулна.</p> <p>$P_c = A_c + B_c I_{m_c} / I_{o_c}$</p> <p>Энд: P_c – гэрээний үнийн "с" валютаар төлөгдөх хэсэгт хийх үнийн тохируулгын үзүүлэлт;</p> <p>A_c ба B_c – гэрээний үнийн "с" валютаар төлөгдөх хэсгийн тохируулга хийгдэхгүй болон хийгдэх хувийн жинг үзүүлсэн, гэрээний тусгай нөхцөлд заасан итгэлцүүр;⁸</p> <p>I_{m_c} – нэхэмжилж буй сарын эцсийн хоногт зонхилж буй "с" валютын индекс; I_{o_c} – тендерийг нээх өдрийн зонхилж буй "с" валютын индекс</p> <p>Хэрэв индексийн дүн нь түүнийг тооцоонд ашигласнаас хойш өөрчлөгдсөн бол тооцоог залруулж, дараагийн төлбөрийн мэдэгдэлд энэ дагуу тохируулга хийнэ. Индексийн дүнг тооцохдоо үнийн хэлбэлзлийн улмаас гарсан зардлын бүх өөрчлөлтийг энд харгалзсан гэж үзнэ.]</p>
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: "Тийм", Урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнтэй тэнцэхүйц урьдчилгаа төлбөрийг олгож болно. Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: Гэрээний төлбөрийн 50 хүртэл хувь байж болно. [мөнгөн дүн бич]
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: Гүйцэтгэгч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг захиалагчид ирүүлсэн өдрөөс хойш ажлын 21 хоногийн дотор захиалагч төлбөрийг олгоно.
ГЕН 5.6.	Төлбөр төлөх хугацаа: 2022 оны сарын ...-ны өдөр Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: 2022 оны сарын ...-ны өдөр

⁸ A_c ба B_c – гэсэн хоёр итгэлцүүрийн нийлбэр нь валют бүрийн томъёонд 1 (нэг) байна. Энэ хоёр итгэлцүүр нь ихэвчлэн ихэнх валютын хувьд ижил байдаг. Төлбөрийн тохируулга хийхгүй хэсэгт зориулсан A итгэлцүүр нь тогтмол үнийн болон бусад тохируулга үл хийгдэх элементүүдийг тусгасан ойролцоо үзүүлэлт (ихэвчлэн 0,15) юм. Валют бүрийн тохируулгын дүнг гэрээний үндэ нэмнэ.

ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: 2022 оны сарын -ны өдөр
ГЕН 6.8.	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: [Чанарын баталгаа “шаардана”/ “шаардахгүй”] Чанарын баталгаа шаардах бол, Чанарын баталгааны хэмжээ: [Гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийн хооронд сонго.]
ГЕН 6.14.	Баталгаат хугацаа: [Тендерийн баримт бичигт үндэслэн баталгаат хугацааг тогтоож бичих]
ГЕН 7.5.	Даатгал: [Ажлын онцлогийг харгалзан гарч болох эрсдэлийг тодорхойлон Гүйцэтгэгчийн даатгуулах даатгалуудыг нэрлэн бичих]
ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: [хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: [хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]